МЭДЭЭ · 2022 оны 2-р сарын 25

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССТОЙ ХАМТРАН ШАЛГАЛТ ХИЙЖЭЭ



Баянхонгор аймгийн прокурорын газраас энэ оны 2 дугаар сарын 18-ны өдөр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогчдын эрх үүрэг, ахуй нөхцөлийг журамласан холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан байна.

Шалгалтыг аймгийн прокурорын газрын ерөнхий прокурор Н.Амарсанаа, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан нар хяналтын прокурор, гишүүдтэй хамтран хийж, хоригдогч нартай биечлэн уулзаж санал хүсэлтийг нь хүлээн авсан байна.

Мөн шалгалтын хүрээнд хоригдогчдын хувийн хэрэг, холбогдох бичиг баримтуудтай танилцаж, гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хяналтын камергүй өрөөг камержуулах, илэрсэн зөрчлийг арилгуулахаар прокурорын шаардлага

хүргүүлжээ.







Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2367